



ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ СТАНДАРТЫГ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-аар арилжаалах хайлуур жоншны хүдэр, баяжмалын /цаашид “бүтээгдэхүүн гэх”/-ын гэрээний стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих, чанарын хяналтыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журамд заасан үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.3 Энэхүү журмыг Биржийн гишүүн брокер, харилцагч, итгэмжлэгдсэн агуулах, терминал, лаборатори, тээвэрлэгч болон бусад оролцогчид дагаж мөрдөнө.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1 СПОТ ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 2.1.1 Гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүн нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 223 дугаар тогтоолын 1-д заасан нэр төрөл, ангилалд нийцсэн байна.
- 2.1.2 Гэрээнд худалдагчаас ирүүлсэн чанарын үзүүлэлтийг тусгана.
- 2.1.3 Гэрээнд нийлүүлэх бүтээгдэхүүний зөрүүд тооцох үнийн нэмэгдэл, бууралтыг тооцох аргачлал, хувь, хэмжээг тусгаж болно.
- 2.1.4 Гэрээ дуусгавар болох хугацаа ажлын өдөр байна.
- 2.1.5 Гэрээгээр арилжаалах хайлуур жоншны хүдэр, баяжмалын 1 багц нь 1 вагон буюу 65 тонн байна.
- 2.1.6 Гэрээний үнэ “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, Төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам”-д заасны дагуу тогтоно.
- 2.1.7 Гэрээний үнийг гадаад валютаар илэрхийлж болно.
- 2.1.8 Гэрээний үнийн хамгийн бага өөрчлөлтийн хэмжээ худалдагч өөрөөр тогтоогоогүй тохиолдолд тонн тутамд 30 цент эсхүл 3 юаньтай дүйцэхүйц байна.
- 2.1.9 Гэрээний арилжааны дэнчингийн хэмжээг “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, Төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам”-д заасны дагуу тогтооно.
- 2.1.10 Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг нь Монгол Улсын эсхүл гадаад улсын хилийн боомт дахь

"хайлуур жоншны хүдэр, баяжмал ачиж буулгах талбай" байна.

- 2.1.11 Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх, хүлээлцэх ажиллагааг энэ журамд нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 2.1.12 Гэрээгээр арилжаалагдах бүтээгдэхүүн нь нь кодоор илэрхийлэгдсэн байж болно.

2.2 ФОРВАРД ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 2.2.1 Гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүн нь тухайн үеийн хүчин төгөлдөр Монгол Улсын стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлттэй бүтээгдэхүүн байна.
- 2.2.2 Гэрээнд худалдагчаас ирүүлсэн чанарын үзүүлэлтийг тусгана.
- 2.2.3 Гэрээнд нийлүүлэх бүтээгдэхүүний чанарын зөрүүд тооцох үнийн нэмэгдэл, бууралтыг тооцох аргачлал, хувь, хэмжээг тусгаж болно.
- 2.2.4 Форвард гэрээ нь биет хүргэлтийн нөхцөлтэй байна.
- 2.2.5 Гэрээ 12 сар хүртэл нөхцөлтэй байна.
- 2.2.6 Гэрээгээр арилжаалах хайлуур жоншны хүдэр, баяжмалын 1 багц нь 1 вагон буюу 65 тонн байна.
- 2.2.7 Гэрээний үнэ "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, Төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам"-д заасны дагуу тогтоно. Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан форвард гэрээний үнийг тохируулж болох бөгөөд үнийн тохируулгын нөхцөл, тооцох аргачлалыг тодорхой тусгана.
- 2.2.8 Гэрээний үнийг гадаад валютаар илэрхийлж болно.
- 2.2.9 Гэрээний үнийн хамгийн бага өөрчлөлтийн хэмжээ худалдагч өөрөөр тогтоогоогүй тохиолдолд тонн тутамд 30 цент эсхүл 3 юаньтай дүйцэхүйц байна.
- 2.2.10 Гэрээний арилжааны дэнчингийн хэмжээг "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, Төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам"-д заасны дагуу тогтооно.
- 2.2.11 Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг нь Монгол Улсын эсхүл гадаад улсын хилийн боомт дахь "хайлуур жоншны хүдэр, баяжмал ачиж буулгах талбай" байна.
- 2.2.12 Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх, хүлээлцэх ажиллагааг энэ журамд нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 2.2.13 Гэрээний нийлүүлэлтийн хуваарийг талууд тохиролцож болно.
- 2.2.14 Гэрээгээр арилжаалагдах бүтээгдэхүүн нь кодоор илэрхийлэгдсэн байж болно.

ГУРАВ. ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТ, ЧАНАРЫН ХЯНАЛТ, ТӨЛБӨР ТООЦОО

Тээвэр логистик

- 3.1 Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх ажиллагааг худалдагчтай гэрээ байгуулсан Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн

үйл ажиллагаа эрхлэгч гүйцэтгэнэ.

- 3.2 Худалдагч нь хүргэлт хийх тээврийн хэрэгслийн дугаар, хүргэлтийн маршрут, бүтээгдэхүүн, тоо хэмжээ, очих хугацааны талаар мэдээллийг итгэмжлэгдсэн агуулах, терминалд бүтээгдэхүүнийг хүргэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 3.3 Худалдан авагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Худалдагч нь бүтээгдэхүүний гэрээнд заасан газарт хүргэх хүртэл хугацааны тээвэрлэлтийн эрсдэлийг хариуцна.
- 3.4 Тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.
- 3.5 Худалдан авагч Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгчийг ашиглахгүйгээр бүтээгдэхүүнийг хүлээн авах бол ачилт хийгдсэнээр хүргэлтийн үйл ажиллагаа дууссан гэж үзнэ.

Агуулахын баримт, хадгалалт

- 3.6 Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, ачилт хийж дуусах хүртэл чанар, тоо хэмжээ, аюулгүй байдлыг хариуцна.
- 3.7 Итгэмжлэгдсэн агуулах терминал нь бүтээгдэхүүнийг хадгалахдаа үндэсний холбогдох стандартад заасан хадгалалтын нөхцөлийг баримтлахаас гадна дараах нөхцөлийг бүрдүүлж ажиллана:
 - 3.7.1 Камерын хяналтын системийг бүрдүүлсэн байх;
 - 3.7.2 Бүтээгдэхүүний овоолгын нэршлийн самбартай байх.
- 3.8 Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь Биржээр арилжих, арилжсан бүтээгдэхүүнийг хүлээн авч, энэ журмын Хавсралт 1 /цаашид “агуулахын баримт” гэх/-г үйлдэн Биржид ирүүлнэ.
- 3.9 Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь итгэмжлэгдсэн лабораториор дээж авхуулах, шинжилгээ хийлгэх үйл ажиллагаанд хамтарч ажиллана. Худалдагч эсхүл брокер нь шинжилгээний дүнг Биржид ирүүлнэ.
- 3.10 Худалдагч нь худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авсан тухай баримтыг Биржид ирүүлснээр Бирж бүтээгдэхүүнийг хүлээн авах мэдэгдлийг худалдан авагч, эсхүл брокер болон итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 3.11 Худалдагч нь агуулах, терминалаас ачилт хийхээс ажлын 3 хоногийн өмнө энэ талаар итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэж, бүтээгдэхүүнийг хүлээн авах этгээдийн биеийн байцаалт, чингэлэг, тээврийн хэрэгсэл болон бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийн талаар мэдээллийг урьдчилан итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 3.12 Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний ачилтыг хийн худалдан авагчид хүлээлгэн өгч акт үйлдэн, итгэмжлэгдсэн лабораторийн

шинжилгээний дүнгийн хамт Биржид ирүүлнэ.

- 3.13 Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүний арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулж, бүртгэгдсэн байна.
- 3.14 Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, хүлээлгэн өгөх бүртгэлийг хөтлөх бөгөөд Бирж нь хяналт, шалгалтын зорилгоор бүртгэл, агуулахын баримтыг тухай бүр шалгах үүрэгтэй.
- 3.15 Агуулахын баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн итгэмжлэгдсэн агуулах, терминал хариуцна.

Төлбөр тооцоо

- 3.16 Худалдан авагч нь өөрийн буруугаас гэрээгээр тогтоосон хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээн аваагүй тохиолдолд агуулах, терминалын төлбөр төлөх бөгөөд агуулахын төлбөрийг дараах байдлаар тооцно:
 - 3.16.1 Агуулах терминалын төлбөрийг тухайн агуулах, терминалын худалдагчтай байгуулсан гэрээнд тусгагдах нөхцөлөөр;
 - 3.16.2 Худалдан авагч бүтээгдэхүүнийг хугацаа хожимдуулан хүлээн авснаас хойш тухайн агуулах, терминалын нэхэмжлэхийн дүнгээр.
- 3.17 Агуулах, терминалын шаардсан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам” болон худалдан авагчтай байгуулсан гэрээнд заасан хариуцлагыг худалдан авагчид хүлээлгэнэ.
- 3.18 Итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх үйлчилгээний төлбөрийг худалдагч хариуцна.

Чанарын хяналт

- 3.19 Худалдагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийлгэх гэрээг биржийн итгэмжлэгдсэн лабораторитой байгуулна.
- 3.20 Итгэмжлэгдсэн лаборатори нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршсан бүтээгдэхүүнээс Монгол Улсын холбогдох стандартад заасан аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийнэ.
- 3.21 Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалд хүлээн авах болон агуулахаас ачилт хийх үеийн жинг үнэн зөв тооцож, баталгаажуулна.
- 3.22 Итгэмжлэгдсэн лаборатори нь бүтээгдэхүүний чанарын шинжилгээг хийж дууссаны дараа шинжилгээний үр дүнгийн хуудасны эх хувийг агуулах, терминалд, хуулбар хувийг Бирж болон худалдагчид хүргүүлнэ.
- 3.23 Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудаст дээжийн мэдээлэл, сорилт, шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, үр дүнг тусгасан байна.

- 3.24 Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалаас ачих үед итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудсыг худалдан авагчид хүлээлгэн өгнө.
- 3.25 Чанарын маргаанаас шалтгаалан агуулах, терминалаас ачилт хийгдээгүй тохиолдолд худалдан авагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэн ачилтыг түр хойшлуулж болно. Энэ тохиолдолд худалдан авагч нь Биржээс бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор давтан шинжилгээ хийлгэх хүсэлтийг Биржид гаргана. Давтан шинжилгээ хийлгэх хүсэлтэд агуулах, терминалын нэр, бүтээгдэхүүний байршил, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, холбоо барих хаяг болон шаардлагатай бусад мэдээллийг тусгаж, албан ёсны тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Давтан шинжилгээг худалдагч, худалдан авагчийн тохиролцож сонгосон Биржийн итгэмжилсэн шинжилгээний лаборатори гүйцэтгэх бөгөөд давтан шинжилгээний үр дүнгээс хамаарч төлбөрийг худалдан авагч эсхүл худалдагч хариуцна.
- 3.26 Худалдан авагч нь заасан хугацаанд тогтоосон журмын дагуу давтан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаагүй тохиолдолд агуулах, терминалаас ачсан бүтээгдэхүүний чанарыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 3.27 Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газраас баталсан холбогдох стандартаар тогтоосон стандарт хазайлтын хүрээнд багтах тохиолдолд шинжилгээний чанар хангалт шаардлага хангасан гэж үзнэ.
- 3.28 Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь зөрүүтэй бөгөөд уг зөрүү нь стандарт хазайлтын хүрээнээс илүү гарсан тохиолдолд худалдагч болон худалдан авагч талуудын хооронд байгуулсан экспортын гэрээ буюу худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулна.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1 Худалдагч, худалдан авагч талууд нь энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан системд хийгдсэн хэлцлийн нөхцөлийг экспортын гэрээндээ заавал тусгах бөгөөд бусад нөхцөлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн харилцан тохиролцож тогтооно.
- 4.2 Бирж нь гэрээний нөхцөлийг өөрчлөх, нэмэлт болон нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй байна.

